

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ

Г.Лхагвамаа. Удирдлагын Академийн
Аюулгүй байдлын удирдлага, стратегийн профессорын
багийн профессор, доктор (Ph.D), хурандаа

Н.Мөнгөнсүлд. Удирдлагын Академийн
магистрант, цагдаагийн хошууч

Хураангуй: Шүүх шинжилгээний байгууллага нь аюулгүй байдлаа бэхжүүлэх, алба хаагчийн хувийн мэдээлэл хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэхэд тал бүрийн шинжилгээ судалгаа зайлшгүй шаардлагатай байна. Энэхүү илтгэлийн хүрээнд нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын алба хаагчдын дунд түүвэр судалгаа явуулснаар тэдгээрийн аюулгүй байдлын тухай ойлголт болон алба хаагчдын хувийн мэдээллийн хамгаалалт, түүнд тулгамдаж байгаа асуудал, нөлөөлөх хүчин зүйлүүдийг илрүүлэх, шийдвэрлэх судалгааны асуулт боловсруулж, санал дэвшүүлж нийтийн хүртээл болгох ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: Шүүхийн шинжилгээний байгууллага, алба хаагч, аюулгүй байдал, хувийн мэдээлэл, хамгаалалт

Оршил

Хэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох нь шинжлэн магадлах байгууллагын хүний нөөцийн ур чадвар, техник технологийн дэвшилт, арга барил, туршлагын цогц байдлаас хамаарах хэдий боловч хэргийг нотлох ажиллагаанд оролцогч, дүгнэлт үйлдсэн алба хаагчийн мэдээлэл хавтаст хэрэгт ил байдаг нь хувь хүний мэдээллийг аюулгүй байдлыг хувийн ашиг сонирхолд ашиглах нөхцөл байдал үүсэх магадлалтай юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагад төдийгүй улсын хэмжээнд алба хаагчийн мэдээллийг хамгаалах эрх зүйн орчин хангалтгүй, түүнд тавих хяналтын систем дутмаг байна. Өөрөөр хэлбэл байгууллага, аж ахуйн нэгжийн алба хаагчийн хувийн

мэдээллийг урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авахгүй цуглуулдаг, хүний хувийн мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашигладаг тохиолдлууд цөөнгүй. Мөн хүний хувийн мэдээлэл хариуцаж, боловсруулж байгаа этгээдийн мэдээллийн эзний өмнө хүлээх үүрэг, хориглох зүйлийг нарийвчлан тогтоогоогүйгээс зөрчил үүссэн ч хариуцлага тооцох боломжгүй байна. Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах харилцаанд тавих төрийн болоод байгууллагын хяналтын талаар, мөн алба хаагчдын мэдээллийн аюулгүй байдлын талаар ойлголт, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох явдал чухлаар хөндөгдөж байна.

Үндсэн хэсэг

Шүүхийн шинжилгээний байгууллагын аюулгүй байдлыг ханган ажиллах нь алсын хараа, эрхэм зорилгыг биелүүлэх түүндээ хүрэх алхам юм. Байгууллагын үндсэн үнэт зүйл болох хүний нөөцийн аюулгүй байдлыг хамгаалах асуудалд анхаарал хандуулахын тулд юуны түрүүнд аюулгүй байдал болон хувь хүний нууц мэдээллийн хамгаалалтын асуудлуудыг тал бүрээс бүрэн бодитой судлах, сайжруулах нь зүйн хэрэг юм.

Судлаачдын тодорхойлсноор:

Аюулгүй байдал гэдэг нь үг зүйн хувьд аюулгүй гэсэн утгатай¹

- Аймаар, жигшмээр зүйлгүй,
- Айх болгоомжлохыг мэдэхгүй гэж тайлбарласан.

Аюулгүй байдал: гэдэг нь тухайн улсад улс төрийн, эдийн засгийн ба нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх ба эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төр, эдийн засгийн, нийгэмшлийн, цэргийн, экологийн, мэдээллийн ба бусад шинжтэй дотоод ба гадаад шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм ба төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал”^{1 2}.

Аюулгүй байдал: гэдэг нь хүмүүс, нийгэм, улс гүрэн, дэлхийн хамтын нийгэмлэгийг мөхөлд хүргэх, материаллаг болон оюун санааны үндсэн хүчин зүйлээс тусгаарлах объектив, субъектив аль

¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1996. 60 дахь тал

² С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. УБ., 2015. 88 дахь тал

ч байдлаар хүлээн зөвшөөрч үл болох, тэвчишгүй хор хохирол тарих, оршин тогтнох, хөгжих зам мөрийг хаадаг уршиг бүхий аюул, заналыг илрүүлэх, судлах, урьдчилан сэргийлэх, сулруулах, таслан зогсоох, устгах, няцаалт өгөх замаар хүмүүс нийгэм, улс гүрэн, дэлхийн хамтын ажиллагаанд суурилсан гадаад болон дотоод аюул заналаас эдгээр субъектийн хамгаалагдсан нөхцөл байдлын илэрхийлэл юм¹.

Аюулгүй байдал гэдэг нь бүхэлдээ хэн ч юунаас ч айж түгшихгүй байх, тийм нөхцөл мөн.² Дээрх ойлголтоос үзэхэд байгууллагын аюулгүй оршин тогтнох үндсийг алба хаагчийн идэвхитэй, албандаа сэтгэлтэй байдлаас хамаарна гэж үзвэл тэдгээрийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах нь нэн тэрүүний үүрэг болно.

Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг:

3.1. Оршин тогтнохуйн аюулгүй байдал

3.2. Эдийн засгийн аюулгүй байдал

3.3. Дотоод аюулгүй байдал

3.4. Хүний аюулгүй байдал

3.5. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал

3.6. Мэдээллийн аюулгүй байдал³

Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал гэх ухагдахуун нь үндэсний аюулгүй байдлын хоёр бүрэлдэхүүн хэсгийг хөндөж байгаагийн хувьд энэхүү агуулгын гол ач холбогдол нь харагдах бөгөөд аливаа байгууллагын хөгжин дэвших үндсийг бүрдүүлж байдаг үнэт зүйл нь хүн тул түүний аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг боловсронгуй болгох нь анхан шатны суурийг бат бөх хөгжүүлэх боломж бололцоог төгөлдөржүүлэх юм.

Хүний аюулгүй байдлыг судлаачдын тодорхойлсноор:

> Хүний аюулгүй байдал гэж Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцлийг

¹ Ч.Улаанхүү. Цэргийн аюулгүй байдал. УБ., 2016. 12 дахь тал

² Ш.Арвай, Ш.Лхачинжав нарын. Монгол улсын хилийн аюулгүй байдлын үндэс. УБ., 2021. 17 дахь тал

³ <https://mfa.gov.mn/28966>

баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлаас хамгаалах үндэс мөн¹.

> Сонгогчийн хувийн мэдээлэл- тухайн иргэнийг гэрчлэх талаар хуульд заасан албан ёсны баримт бичигт туссан мэдээлэл, гэрэл зураг, бийеийн давхцахгүй өгөгдлийг /гарын хурууны хээ/ ².

> “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо хандлагыг эсрэг хэнч бай хуулиар хамгаалуулах эрхтэй”³.

> “...халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй..... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”⁴.

> “ Хувь хүний нууц” гэж Монгол улсын болон гадаадын иргэн харъяалалгүй хүн Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулвал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ⁵.

Дээрх ойлголтуудаас үзэхэд хувь хүний аюулгүй байдал, хамгаалах шаардлагатай мэдээллийг байнга судлан боловсруулж, өргөн хүрээнд авч үзэх нь зайлшгүй юм. Хүний хувийн нууц мэдээлэл алдагдах хэлбэрээр хөндөгддөг тул түүний хамгаалалтыг сайжруулах, болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх нь чухал.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс нь мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах⁶ асуудал гэж ойлгож болно.

¹ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.УБ., 2010.3.34 дэхь заалт

² Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль. 2011 Төрийн мэдээлэл №48

³ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12-р зүйл

⁴ Монгол улсын үндсэн хуулийн 16-р зүйлийн 13 дахь хэсэг.1992. Төрийн мэдээлэл №1

⁵ Хувь хүний нууцын тухай хуулийн 2-р зүйл. 1995. Төрийн мэдээлэл №7

⁶ Монгол Улсын их хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын Тамгын газрын хэвлэх цех., УБ., 2016.16 дахь тал

Хувийн мэдээлэл гэж хувь хүнийг шууд тодорхойлох боломжтой аливаа мэдээллийг ойлгоно¹ гээд

Онцгойлон хамгаалах хувийн мэдээлэл²:

> Арьс өнгө, үндэс угсаа
> Улс төрийн үзэл бодол, шашины болон бусад итгэл үнэмшил

> Эрүүл мэндийн болон хүйсийн амьдрал
> Ял шийтгэлийн тухай мэдээлэл
> Хуульд өөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эцэг /эх/-н нэр өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулахыг хориглоно³.

> Хүний амин чухал үнэт зүйлс нь амь нас, эрүүл мэнд байдаг тул, хүний олон хэрэгцээ дотроос аюулгүй байдал нэн тэргүүний байр суурийг эзэлнэ⁴.

> "Хувь хүний нууц" гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ⁵.

> Хувь хүний нууцад захидал харилцааны нууц; эрүүл мэндийн нууц; хөрөнгийн нууц; гэр бүлийн нууц, хуулиар тогтоосон бусад нууцууд хамаарах⁶-аар холбогдох хуулиудад тусгасан байна.

Хувийн мэдээллийн ихэнх хэсэг хамгаалагдаж байгаа ч хувийн мэдээллийн халдашгүй байх боломж хомсдож байна. Мэдээллийн технологийн хөгжил, түүнийг дагалдсан үй олон хэмжээний мэдээллийн цахим, нэгдсэн сан бий болж байгаа нь энэ төрлийн мэдээллийг тараах, хуулбарлах, нэгтгэхэд энгийн, хялбар, хувиргаж өөрчлөх боломжтой болсон зэрэг нь хувь хүний ашиг сонирхолд нэмэлт аюул занал үүсгэж байна.

¹ Хувийн мэдээллийг автоматжуулсан системд боловсруулах үед хувь хүнийг хамгаалах тухай Европын холбооны Конвенцийн 2-р зүйл

² Европын холбооны Конвенцийн 6-р зүйл

³ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль.20-р зүйл, 2011, Төрийн мэдээлэл №26

⁴ Ш.Арвай, Ш.Лхачинжав нарын. Монгол улсын хилийн аюулгүй байдлын үндэс. УБ., 2021. 138 дахь тал

⁵ Хувь хүний нууцын тухай хууль 1-р бүлэг 2-р зүйл

⁶ Ш.Арвай, Ш.Лхачинжав нарын. Монгол улсын хилийн аюулгүй байдлын үндэс. УБ., 2021. 141 дэх тал

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Мэдээллийн бүрэн бүтэн байдал”-г хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно.¹ “Мэдээллийн нууцлал”-ыг Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, мэдээллийн нууц, нэр төрөө хамгаалах эрх, эрх чөлөөнд халдахыг хориглоно^{1 2} гэж тусгасан байна.

“Хувь хүний мэдээллийг хамгаалах” тухай хуулийн төсөлд хүний хувийн мэдээлэл цуглуулахад мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах, мэдээллийн эзний эрх, үүрэг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах, хүний хувийн мэдээлэл хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүний хувийн мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагын чиг үүрэг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулах тохиолдол болон хориглох зэрэг олон чухал зохицуулалтууд оруулж хэлэлцэж байгаа нь сайшаалтай хэрэг. Хүний хувийн мэдээлэл хамгаалах эрх зүйн орчинг сайжруулах, хүний хувийн мэдээллийг тодорхой нөхцөл, зорилготойгоор, хуульд заасны дагуу цуглуулах, боловсруулах, ашиглах эрх зүйн үндэс бий болох төдийгүй хүний хувийн мэдээллийг зүй зохистойгоор ашиглах боломжийг зааж өгөх, мөн хүний хувийн мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлж, хүний эрхийн баталгаа хангагдана гэж үзэж байгаа юм. Хуулийн төслийн хэрэгжих байдал өнөөгийн шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын хувийн мэдээллийг хамгаалахад дөхөм болох юм.

Шүүхийн Шинжилгээний байгууллагын хувьд: Анх 1928 онд Дотоодыг хамгаалах газрын даргын тушаалаар шифрийн нууц тусгай тасагт гэрэл зурагчны орон тоог шинээр бий болгож криминалистикийн тоо бүртгэлийг хөтөлж эхэлсэн нь³ Монгол Улсад орчин үеийн шинжлэн магадлах байгууллагын эхлэл нь “нууц” гэсэн

¹ Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3.6.2.3

² Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3.6.3.6

³ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн архивийн баримт бичиг

нэршилтэй байсан нь байгууллагын болон алба хаагчийн мэдээлэл нууц байх үндсийг бүрдүүлж байсан нь харагдаж байна.

“Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал хамгаалалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагатай холбогдуулан доорх таамаглалыг дэвшүүлсэн юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаандаа баримталдаг хууль, хуульчилсан актад шинжээчийн дүгнэлтэд: Шинжилгээ хийж буй шинжээчийн тухай мэдээлэл, /овог, нэр, боловсрол, мэргэжил, ажилласан жил, цагдаагийн цол, эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол, албан тушаал/¹ тусгаж өгсөн нь тухайн хавтаст хэрэгтэй танилцах эрх бүхий этгээд хувийн ашиг сонирхлын хэрэгцээнд мэдээллийг авах, тухайн хэрэгт нотлох чиг үүргээр оролцсон шинжээч, мэргэжилтний хувь хүний бие махбод, эрүүл мэнд, өмч, гэр бүлийн аюулгүй байдалд бодитоор хохирол учрах, авилга хээл хахуульд өртөх магадлалыг нэмэгдүүлэх, эрх бүхий албан тушаалтны шахалт дарамтад орох гэх мэт байдлаар ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн хэмжээнд хэрэгжүүлэх хуулиар хүлээсэн үүрэг, өргөсөн тангарагтаа үнэнч байх, өөрийн үзэл баримтлалаа дээдлэх зарчимд сөргөөр нөлөөлөх эрсдэл байгаа эсэх.

Энэхүү таамаглалыг тодруулахаар: Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын нийт 35 алба хаагчийг хамруулж, Google form-оор судалгаа явуулахад: Оролцогчдын тоо, хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй байгаа нь тус газар хүйсийн харьцаа тэнцвэртэй байгааг нотоллоо. Насны хувьд 21-46 төрийн албан хаагчид илүү ажиллаж байгаа нь зөвхөн энэ судалгаанд оролцсон оролцогчдын үр дүнгээс дүгнэлт өгөхөд хүргэж байна.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын тоо, насны байдал, хүйсээр

Үзүүлэлт	Шинж байдал	Судалгаанд оролцогчид	
		Тоо	Хувиар
Хүйс	Эрэгтэй	17	48,6
	Эмэгтэй	18	51,4
нийт		35	100
Нас	20-29	13	37,1

¹ Хуульзүй, дотоод хэргийн сайдын тушаал 2010/119.3.3.4


	30-39	16	45,8
	40-50	6	17,1
нийт		35	100
Боловсролын түвшин	Бакалавр	18	51,4
	Магистр	17	48,6
нийт		35	100

Тайлбар: Судалгааны үр дүнгээс

Хүснэгт 2. Шүүхийн шинжилгээний байгууллагад ажилласан жил

Үзүүлэлт	Шинж байдал	Судалгаанд оролцогчид	
		Тоо	Хувиар
Шүүхийн шинжилгээний байгууллагад ажилласан жил	1-5 жил	13	37,1
	5-10 жил	16	45,7
	11-с дээш жил	6	17,2
нийт		35	100

Зураг1. Алба хаагчийн хувийн мэдээллийн аюулгүй байдалд нөлөөллж болзошгүй хүчин зүйл



Судалгаанаас үзэхэд алба хаагчдын хувьд байгууллага болоод хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын талаар тодорхой ойлголтгүй байгаа нь харагдаж байгаа тул аюулгүй байдлын асуудлыг байгууллагын менежменттэй холбон судлах нь зохимжтой гэж үзлээ. Хувь хүн нууцаа өөрөө хамгаалах үүрэгтэй хэдий ч

шүүхийн шинжилгээний байгууллагын хувьд алба хаагчид шинжилгээ хийж, дүгнэлт гаргахтай холбоотойгоор шинжээчийн дүгнэлтийн удиртгал хэсэгт хувийн мэдээллээ /овог, нэр, боловсрол, мэргэжил, ажилласан жил, цагдаагийн цол, эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол, албан тушаал/ ил болгодог. Иймд алба хаагчийг гэмт халдлага, албан тушаалтан болон бусад ашиг сонирхол бүхий этгээдийн гэмт үйл ажиллагаанаас хамгаалахын тулд мэдээллийн нууцыг хамгаалалтдаа авах, хяналт тавих хэрэгцээ шаардлага бий болж байна.

Энэхүү асуудал хөндөгдөж байгаа үед хүний хувийн нууцын эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор “Хувийн мэдээллийн хамгаалалтын тухай” хуулийн төсөл хэлэлцэж байгаа нь ач холбогдолтой байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү илтгэлийн хүрээнд Монгол улс дахь хүний хувийн мэдээллийн эрх зүйн зохицуулалт, хамгаалалтын өнөөгийн байдлыг судалж дүгнэхэд:

Төр болон бизнесийн байгууллага хувийн мэдээллийг цуглуулахад зөвшөөрөл авах түүнд тавигдах шаардлага тогтоогоогүй, стандарт байхгүй

Лавлагаа мэдээлэл гаргаж өгөх, мэдээллийг бусад байгууллагад шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтгүй

Хувийн мэдээлэл хамгаалах баталгаа гаргахад тодорхой үүрэг, хариуцлага хүлээлгэдэг механизм байхгүй байгаа нь илүү нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

Тиймээс хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу алба хаагчийн хувийн мэдээлэлтэй танилцах тохиодолд шат дараалан эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл авдаг, нууцын баталгаа өгдөг байх, хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулсан тохиолдолд тооцох хариуцлага тодорхой байхаас гадна хяналтын тогтолцоотой болох шаардлагатай байна.

Хувь хүний нууцыг зөвхөн хохирол учруулах агуулгаар бус, илүү өргөн агуулгаар тодорхойлж, хамгаалах шаардлага тулгарч

байна. Байгууллагын аюулгүй байдлын гол үнэт зүйл нь алба хаагчийн хувийн аюулгүй байдал учир түүний мэдээллийн аюулгүй байдлыг байгууллага хамгаалдаг байх алба хаагч бүр тухайлсан тодорхой ойлголттой болох нь нэн тэргүүний асуудал гэж үзээд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шинжилгээний байгууллагын алба хаагчдад байгууллагын болоод өөрийн аюулгүй байдлаа хангахын тул мэдээллийн нууцыг хамгаалахад чиглэсэн тусгайлсан сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж, алба хаагчдыг идэвхижүүлэх.

2. Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид шинжилгээ хийж, дүгнэлт гаргахтай холбоотойгоор шинжээчийн дүгнэлтийн удиртгал хэсэгт хувийн мэдээллээ /овог, нэр, боловсрол, мэргэжил, ажилласан жил, цагдаагийн цол, эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол, албан тушаал/ ил болгодог. Энэ нь нэг талаас алба хаагчийг гэмт халдлагад өртөх, албан тушаалтан болон бусад ашиг сонирхол бүхий этгээдийн гэмт үйл ажиллагаанд өртөх эрсдлээс сэргийлж, байгууллага хувь хүний мэдээллийн нууцыг хамгаалалтдаа авах, хяналт тавих тогтолцоог, задруулсан тохиолдолд тооцох хариуцлага тодорхойлон зохицуулсан эрх зүйн баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын үндсэн хууль., 1992 он

Шүүхийн шинжилгээний тухай хууль., 2009 он

Хувь хүний нууцын тухай хууль., 1995 он

Хувийн мэдээллийг автоматжуулсан ситемд боловсруулах үед хувь хүнийг хамгаалах тухай Европын холбооны Конвенц

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль., 2011 он

Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль., 2011 он

Хүний эрхийн түгээмэл тунхаглал., 1946 он

Хуульзүй, дотоод хэргийн сайдын тушаал 2010/119

Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт.,

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээчийн гарын авлага., 2008 он

Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээчийн гарын
авлага., 2010 он

ШШҮХ-ийн захирлын тушаал, дугаар 41.,2008.03.18

ШШБ-ын нууцад хамаарах бичиг баримтуудын эмхэтгэл

Ном зохиол, сурах бичиг

Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1996 он

Б.Одбаатар., “Байгууллагын удирдлага”. УБ., 2015 он

Ч.Өрнөхбаяр, М.Ахиунаа, Д.Отгонтуяа., “Төрийн онол”
гарын авлага., УБ., 2007 он

С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. УБ., 2015
он

Ч.Улаанхүү. Цэргийн аюулгүй байдал. УБ., 2016 он

Ш.Арвай, Ш.Лхачинжав нарын. Монгол улсын хилийн
аюулгүй байдлын үндэс. УБ., 2021 он

Цахим эх сурвалж

<https://mfa.gov.mn/28966>

www.google.com